



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 21 өдөр

Дугаар А/497

Ховд

Дөргөн сумын Ахуй үйлчилгээний  
барилгын засварын ажлыг хүлээн авах  
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын “б”, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 1 дүгээр хавсралтын 1.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Зөөлөн тэмүүлэл констракшн” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн Ахуй үйлчилгээний төвийн барилгын их засвар /Ховд, Дөргөн сум/-н ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн  
ахлагч: Б.Баярсүх

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого,  
төлөвлөлтийн хэлтсийн дарга

Гишүүд: Д.Нямтулга

- Мэргэжлийн хяналтын газрын барилгын  
техникийн хяналтын улсын байцаагч

Н.Цацралцэцэг

- Мэргэжлийн хяналтын газрын  
эрчим хүчний хяналтын улсын байцаагч

Б.Түмэндэмбэрэл

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого,  
төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Ц.Цолмонбаатар

- Стандарт хэмжил зүйн хэлтсийн  
салбар сан хариуцсан мэргэжилтэн

Л.Цэдэн-иш

- Дөргөн сумын Засаг дарга

Б.Бурмаа

- Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

С.Батдорж

- Аймгийн Архивын тасгийн дарга

- |                                       |  |
|---------------------------------------|--|
| Д.Батсайхан                           | - Барилгын зураг төслийн<br>“Алтайн сүрлэг цамхаг” ХХК-ийн захирал   |
| У.Болдбаяр                            | - “Зөөлөн тэмүүлэл констракшн” ХХК-ийн<br>захирал  |
| Нарийн бичгийн<br>дарга: Д.Тогтохбаяр | - Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын<br>газрын Барилга, хот байгуулалтын<br>хэлтсийн ахлах мэргэжилтэн |

2. “Зөөлөн тэмүүлэл констракшн” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн ажлыг захиалагчаас өгөгдсөн ажлын тоо хэмжээтэй тулган шалгаж, өмч бүртгэлд тусгаж хүлээн авах эсэх талаар шийдвэр гарган танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Баярсүх/-д даалгасугай.

3. Дээрхи ажилтай холбогдолтой гарах зардлыг захиалагчийн хяналтын зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН  
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН